

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАРИФЫН ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү дүрмийн зорилго нь төмөр замын тээврийн тарифыг оновчтой тогтоох, өөрчлөх, шинэчлэх асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий Зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2.Зөвлөл нь төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх орон тооны бус зөвлөл байна.

1.3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Төмөр замын тээврийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт, энэхүү дүрмийг дагаж мөрдөх бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн зарчим, шаардлагыг харгалзан үзэж ажиллана.

1.4. Зөвлөл нь тээврийн салбарын бодлого, тарифын зохицуулалтыг ил тод, мэргэжлийн үндэслэлтэй болгоход дэмжлэг үзүүлэх зорилготойгоор ажиллана.

1.5. Зөвлөл нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.

- 1.5.1.хууль дээдлэх, хууль зүйн үндэслэлтэй байх;
- 1.5.2.ил тод нээлттэй, эрх тэгш, зах зээлийн нөхцөлд нийцсэн байх;
- 1.5.3.хараат бус, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- 1.5.4.олон нийтийн оролцоог хангах;
- 1.5.5.төмөр замын тогтвортой хөгжлийг дэмжих;
- 1.5.6.салбарын онцлогт тохирсон байх;
- 1.5.7.бүс нутгийн нөхцлийг харгалзсан байх.

Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагаа

2.1.Зөвлөл нь төмөр замын тээврийн тарифыг оновчтой тогтоох чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг явуулна.

2.1.1.төмөр замын тээврийн тариф тогтоох, шинэчлэх, өөрчлөх, хянах, санал дүгнэлт, зөвлөмж гаргах;

2.1.2.тарифын нөлөөллийн судалгаа, тооцоог мэргэжлийн байгууллагаар хийлгэх;

2.1.3.олон нийтийн болон хэрэглэгчдийн санал хүсэлтийг харгалзан үнэлгээ хийх;

2.1.4.тарифын төсөлд хяналт-шинжилгээ хийх,

2.1.5.бусад салбарын уялдаа холбоог судлах;

2.1.6.тарифын бодлогын хэрэгжилт, үр нөлөөг үнэлэх тайлан гаргаж, холбогдох байгууллагад танилцуулах;

2.1.7.олон нийтийг мэдээллээр хангах, уулзалт, хэлэлцүүлэг, сургалт, зохион байгуулах.

2.2.Зөвлөл нь үйл ажиллагааны хагас, бүтэн жилийн төлөвлөгөөгөө, үнэлгээ хийх хуваарийн хамт боловсруулж, тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор зөвлөлийн дарга батална.

2.3.Зөвлөл нь төмөр замын тээврийн салбарын хөгжилтэй уялдуулан тарифыг оновчтой тогтоох, өөрчлөх, шинэчлэх асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах арга хэмжээг энэхүү дүрмийн 2.2-т заасан хагас, бүтэн жилийн төлөвлөгөөгөөр хязгаарлахгүй бөгөөд төлөвлөгөөнөөс гадна хийгдэх нэмэлт арга хэмжээг Зөвлөлийн даргын шийдвэрээр зохион байгуулан хэрэгжүүлж болно.

2.4.Зөвлөлийн гаргасан зөвлөмж нь төрийн байгууллагад зөвлөмжийн шинжтэй бөгөөд шийдвэр гаргах үйл явцад суурь баримт болно.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр

3.1.Зөвлөл нь чиг үүргээ дүгнэлт, зөвлөмж гаргах арга хэлбэрээр хэрэгжүүлэх бөгөөд Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

3.2.Хуралдааныг хагас жил тутам 1-ээс доошгүй удаа хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн дарга, эсхүл гишүүний саналаар хуралдааныг зарлаж болно.

3.4.Хуралдаанаар Зөвлөлийн энэхүү дүрэмд заасан чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэнэ.

3.5.Зөвлөлийн нийт гишүүдийн бүрэн оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.6. Хуралдааны дэгийг хууль, журамд заасан нийтлэг зохицуулалтын дагуу боловсруулж хуралдаанаараа хэлэлцэн батална.

3.7.Зөвлөлийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.7.1.төмөр замын тээврийн тарифыг оновчтой тогтоох, өөрчлөх, шинэчлэх;

3.7.2.зөвлөлийн үйл ажиллагааны хагас, бүтэн жилийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт, үр дүнгийн тайлан;

3.7.3.зөвлөлийн чиг үүргийн хүрээнд хамаарах бусад асуудал.

3.8.Зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар гаргасан шийдвэрийг хуралдааны тэмдэглэлээр албажуулна. Хуралдааны тэмдэглэлд гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

3.9.Зөвлөлийн чиг үүргийн хэрэгжилтийг хангах, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх зорилгоор тарифтай холбоотой баримт бичиг, мэдээллийг гишүүдэд 5-аас доошгүй хоногийн өмнө танилцуулсан байна.

3.11.Зөвлөл нь нийгэм, эдийн засаг, олон улсын зах зээлийн судалгааг иргэн, ашгийн төлөө бус байгууллагын оролцоотойгоор багийн зохион байгуулалтаар гүйцэтгүүлж болох бөгөөд багийг Зөвлөлийн гишүүн ахална. Багийн ахлагч, бүрэлдэхүүнийг Зөвлөлийн дарга тогтооно.

3.12.Зөвлөлийн ажиллах нөхцөлийг Төмөр замын газар хангана.

3.13. Зөвлөл нь Төмөр замын газрын цахим хуудсанд өөрийн үйл ажиллагааны тайлан, мэдээллийг тогтмол байршуулна.

Дөрөв. Зөвлөлийн бүрэлдэхүүний эрх, үүрэг

4.1. Зөвлөлийн дарга нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1.зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

4.1.2.дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх, хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах;

4.1.3.хуралдааны тов тогтоох, хэлэлцэх асуудлын жагсаалтыг хянах, хуваарийг батлах, хуралдааныг даргалах;

4.1.4.энэхүү дүрмийн 2.2-т заасан төлөвлөгөөнөөс гадна нэмэлт арга хэмжээг зохион байгуулах;

4.1.5.зөвлөлөөс гаргасан санал, дүгнэлт, зөвлөмжийг Төмөр замын газраар дамжуулан холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулах;

4.1.6.зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг төсөвлөн батлуулах, төсөв, санхүүжилтийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах;

4.1.7.зөвлөлийн үйл ажиллагаа болон зардлын зарцуулалтыг тус зөвлөлийн хуралдаанд жил тутам танилцуулах, Төмөр замын газрын санхүүд зохих журмын дагуу тайлагнах ажлыг зохион байгуулах.

4.2. Зөвлөлийн гишүүн нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.2.1.энэ дүрэмд заасан төлөвлөгөө, хуваарийн дагуу тариф хариуцагчийн тарифын хэрэгжилтэд үнэлгээ хийж, Зөвлөлд үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх, зөвлөмж боловсруулах;

4.2.2.зөвлөлийн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд бүрэн оролцох;

4.2.3.зөвлөлийн ажлын төлөвлөгөө, хэлэлцэх асуудалд саналаа өгөх;

4.2.4.зөвлөлийн хуралдааны дэгийг сахих;

4.2.5.хийсэн үнэлгээнийхээ үр дүнгийн бодит байдлыг хариуцах;

4.2.6.чиг үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн мэдээллийн нууцлалыг задруулахгүй байх.

4.3. Ашгийн бус хуулийн этгээдийн төлөөлөл-гишүүн нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын хараат бус, бие даасан эрх зүйн байдлын хүрээнд Зөвлөлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлж, хүний эрхийн чиглэлээр зөвлөх чиг үүрэгтэй оролцоно.

4.4. Төмөр замын газар нь зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус газрын албан хаагчийг томилно.

4.5. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Зөвлөлийн хуралдаанд саналын эрхгүй бөгөөд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.5.1. зөвлөлийн хуралдаан болон бусад арга хэмжээний зохион байгуулалтын бэлтгэлийг хангах, хуралдааны тэмдэглэл хөтлөх, албажуулах;

4.5.2. зөвлөлийн албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль, журам, стандартын дагуу хариуцан явуулах, зөвлөлийн төлөвлөгөө, тайланг нэгтгэн боловсруулах;

4.5.3. зөвлөлийн баримт бичгийг архивын нэгж болгон хуулийн хугацаанд Төмөр

замын газрын архивын эрхлэгчид зохих журмын дагуу хүлээлгэж өгөх;

4.5.4.Зөвлөлийн мэдээллийг бэлтгэж, Төмөр замын газрын цахим хуудсанд байршуулах, зөвлөлийн үйл ажиллагааны тайланг яаманд хүргүүлэх.

Тав. Хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах

5.1. Зөвлөл нь чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд хүн, хуулийн этгээдтэй дараах байдлаар хамтран ажиллаж болно.

5.1.1.чиг үүргийн хүрээнд хамтарсан үнэлгээний ажил гүйцэтгэх, хэлэлцүүлэг зохион байгуулах;

5.1.2.чиг үүргийн хүрээнд төрийн байгууллагын холбогдох баримт мэдээлэлтэй танилцах, хүн, хуулийн этгээдээс мэдээлэл, санал, асуулга авах;

5.1.3. чиг үүргийн хүрээнд мэдээлэл солилцох, уулзалт, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах, олон нийтэд мэдээлэл түгээх ажлыг хамтран зохион байгуулах.

5.2. Зөвлөл хүн, хуулийн этгээдтэй Төмөр замын газрын даргаар дамжуулан харилцах ба Төмөр замын газрын хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ. Энэ үйл ажиллагаанд Төмөр замын газрын албан хэрэг хөтлөлтийн журмыг мөрдлөг болгоно.

Зургаа. Зөвлөлийн үйл ажиллагааны нөхцөл, санхүүжилт

6.1.Зөвлөлийн дарга, гишүүнд оролцооны урамшуулал, үнэлгээ, судалгаа хийхэд гэрээний дагуу оролцуулсан хүн, хуулийн этгээдэд ажлын хөлс олгож болно. Урамшуулал, ажлын хөлсний хэмжээг Төмөр замын газрын дарга тогтоон олгоно.

6.2. Урамшууллын хэмжээг Зөвлөлийн ажилд оролцсон байдал, ажлын үр дүнг харгалзан Зөвлөлийн даргын саналыг үндэслэн тогтоон олгож болно.

6.3. Үнэлгээнд оролцуулсан хүн, хуулийн этгээдийн ажлын хөлсийг гэрээний биелэлт, ажлын гүйцэтгэлийг үндэслэн Төмөр замын газар олгож болно.

6.4. Төмөр замын газар нь Зөвлөлийг ажиллах байр, хуралдааны танхим болон шаардлагатай бусад техник тоног төхөөрөмж, мэдээллээр хангах ба Зөвлөлийн үйл ажиллагааны зардал, дарга, гишүүдэд олгох урамшуулал болон бусад хөлс, төлбөрийг улсын төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх асуудлыг хариуцна.